

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/024/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/316
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН
ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.БАТТУШИГ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр 211.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 124.7 сая төгрөгийн алдааг залруулж, орон нутгийн орлого бүрдүүлэлт, өр төлбөтэй холбоотой 15.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Хатгал тосгоны Захирагч нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээг 74.2 хувьтай дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		827,308.96	1,191,509.21
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	648,260.88	860,453.65
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	-	20,000
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	179,048.08	311,055.56
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,346,477.91	5,474,181.05
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,346,477.91	5,474,181.05
Биет хөрөнгө		2,233,856.91	5,361,818.05
Биет бус хөрөнгө	13	112,621	112,363
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,173,786.87	6,665,690.26
НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,722.26	24,280.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,722.26	24,280.4
Өглөг		5,722.26	24,280.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,168,064.61	6,641,409.86
Засгийн газрын хувь оролцоо		3,168,064.61	6,641,409.86
Засгийн газрын оруулсан капитал		338,189.44	338,189.44
Хуримтлагдсан үр дүн		2,636,397.46	6,109,742.71
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		193,477.71	193,477.71
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,173,786.87	6,665,690.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,737,414.64	5,187,050.7
ТАТВАРЫН ОРЛОГО		839,232.95	939,535.09
Орлогын албан татвар		640,017.77	736,999.92
Хөрөнгийн албан татвар		38,619.54	47,638.24
Бусад татвар, төлбөр, хураамж		160,595.64	154,896.93
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	207,448.24	4,247,515.61
Хөрөнгийн орлого		3,150	4,393.75
Тусламжийн орлого		0.0	469,959.41
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		690,733.46	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,407,083.32	1,702,961.96
УРСГАЛ ЗАРДАЛ		1,407,083.32	1,702,961.96
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,355,326.51	1,702,861.96
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		552,937.27	673,564.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		78,376.7	95,616.44
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		252,295.41	289,932.8
Хангамж, бараа материалын зардал		52,500.54	63,142.03
Нормативт зардал		4,985	1,838
Эд хогшил, урсгал засварын зардал		47,244.75	33,213.55
Томилолт, зочны зардал		10,672.75	2,810
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		97,731.12	117,945.64
Бараа үйлчилгээний бусад зардал		258,582.98	424,798.89
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		51,756.8	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		330,331.32	3,484,088.75
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		37,284.41	10,743.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-37,284.41	-10,743.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		293,046.91	3,473,345.25

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
-------------------	------------------------	------------------------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,635,317.77	1,626,720.41
ТАТВАРЫН ОРЛОГО	839,232.95	939,535.09
Орлогын албан татвар	640,017.77	736,999.92
Хөрөнгийн албан татвар	38,619.54	47,638.24
Бусад татвар, төлбөр, хураамж	160,595.64	154,896.93
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,951.37	687,185.32
Нийтлэг татварын бус орлого	102,801.37	62,671.66
Хөрөнгийн орлого	3,150	4,393.75
Тусламжийн орлого	0	469,959.41
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	150,160.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	690,133.46	0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,216,386.42	1,274,517.99
УРСГАЛ ЗАРДАЛ	1,216,386.42	1,274,517.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,164,729.62	1,274,417.99
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	575,670.01	695,677.37
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,894.41	95,616.44
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,364.91	297,799.77
Хангамж, бараа материалын зардал	56,457.39	47,538.17
Нормативт зардал	0	1,838
Эд хогшил, урсгал засварын зардал	34,806.9	35,547.05
Томилолт, зочны зардал	10,672.75	2,810
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,694.29	82,805.39
Бараа үйлчилгээний бусад зардал	21,168.96	14,785.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,656.8	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	418,931.35	352,202.42
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	233,704.65	140,009.66
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	233,704.65	140,009.66
Дотоод эх үүсвэрээр	233,704.65	140,009.66
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-233,704.65	-140,009.66
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	185,226.7	212,192.77
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	463,034.19	648,260.88
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	648,260.88	860,453.65

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,017.7	2,875,017.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,875,017.7	2,875,017.7
Тайлант үеийн үр дүн	293,046.91	293,046.91
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,168,064.61	3,168,064.61
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,168,064.61	3,168,064.61
Тайлант үеийн үр дүн	3,473,345.25	3,473,345.25
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,641,409.86	6,641,409.86

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,644,929.0	1,325,993.9	318,935.1	80.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,408,082.9	1,192,691.7	215,391.2	84.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,384,348.1	1,192,591.7	191,756.4	86.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	770,692.7	673,564.6	97,128.1	87.4

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210101	Үндсэн цалин	569,470.2	366,416.3	203,053.9	64.3
210102	Нэмэгдэл	192,392.5	282,970.8	(90,578.3)	147.1
210104	Урамшуулал	8,830.0	24,177.5	(15,347.5)	273.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,956.4	87,956.4	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	57,128.4	57,128.4	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,707.0	7,707.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,853.5	3,853.5	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,853.5	3,853.5	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,414.0	15,414.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,947.8	296,428.2	18,519.6	94.1
210301	Гэрэл, цахилгаан	109,480.4	76,111.4	33,369.0	69.5
210302	Түлш, халаалт	180,733.5	196,849.0	(16,115.5)	108.9
210303	Цэвэр, бохир ус	24,733.9	23,467.8	1,266.1	94.9
2104	Хангамж, бараа материалын зардал	30,187.3	29,881.3	306.0	99.0
210401	Бичиг хэрэг	1,928.1	1,928.0	0.1	100.0
210402	Тээвэр, шатахуун	17,000.0	17,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,125.0	3,819.2	305.8	92.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,795.1	5,795.0	0.1	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,339.1	1,339.1	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,484.8	35,547.1	5,937.8	85.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	184.8	184.8	-	100.0
210604	Урсгал засвар	41,300.0	35,362.3	5,937.8	85.6
2107	Томилолт, зочны зардал	2,810.0	2,810.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	2,810.0	2,810.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,788.8	51,618.4	92,170.4	35.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,776.8	49,709.2	92,067.7	35.1
210803	Даатгалын үйлчилгээ	204.4	204.3	0.2	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	407.6	407.5	0.1	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400.0	400.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.0	897.5	102.5	89.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,105.0	14,785.8	1,319.2	91.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,494.9	11,175.8	1,319.1	89.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,610.1	3,610.0	0.1	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110.1	100.0	10.1	90.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	110.1	100.0	10.1	90.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110.1	100.0	10.1	90.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	236,846.1	133,302.2	103,543.9	56.3
223001	Бусад хөрөнгө	236,846.1	133,302.2	103,543.9	56.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,644,929.0	1,554,372.9	90,556.1	94.5
122	Тусламжийн орлого	1,644,929.0	1,554,372.9	90,556.1	94.5
122005	Орон нутгийн төсвөөс	1,167,928.8	1,404,212.4	(236,283.6)	120.2
120043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	318,256.3		318,256.3	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	158,743.9	150,160.5	8,583.4	94.6

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		630,266.3		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		858,645.4		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,824.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,824.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,148.7
2104	Хангамж, бараа материалын зардал	10,698.8
210402	Тээвэр, шатахуун	10,698.8
2105	Нормативт зардал	1,838.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,838.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,611.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,611.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,675.5
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	24,675.5
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,824.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,824.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,572.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,251.8
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Захирагчийн ажлын алба	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Хатгал цахир ОНӨААТҮГ	Түүвэрт хамрагдсан
5	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 71.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 46.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 21.2 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар нийт 124.7 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 124.7 сая төгрөгийн орлого, зардлын хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй алдааг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 15.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл малд ногдуулах албан татварыг 1.2 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 8.0 сая төгрөгөөр, нийт 9.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, нэр төрөл бүрээр биелэлтийг хангаж ажиллах

2. **Өр төлбөртэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд үүссэн 13.4 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үүссэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, цаашид өр төлбөр үүсэхгүй байхад анхаарч ажиллах

3. **Чанарын баталгаатай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Хатгал тосгоны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдсэн "УТХГ, Хүзүүвчийн чиглэлийн өндөр хүчдэлийн трансформатор" төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо барьцааг суутгахгүйгээр олгосон байна. Энэ нь төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Эко ньуу теч ХХК-тай байгуулсан №ХӨАХТЗА/2025020111 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний 13.14 дахь хэсэгтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Чанарын баталгааг гэрээнд заасны дагуу суутгаж, зүгшрүүлэх тохируулах хугацаа дуусгавар болсны дараа чөлөөлөх

4. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр зориулалттай холбоотой сар тутам мэдээлэх 6 тайлан нийт 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

			/сая төгрөгөөр/	
	Нийт алдаа			Үүнээс

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитад хамрагдсан байгууллагын нэр			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хатгал тосгоны ТТЗ	1	124.7	1	124.7			1	124.7		
Дүн	1	124.7	1	124.7			1	124.7		
Харьяа байгууллагуудын алдаа										
Хатгал ЗАА	3	46.6			3	46.6	3	46.6		
Дүн	3	46.6			3	46.6	3	46.6		
НИЙТ Дүн	4	171.3	1	124.7	3	46.6	4	171.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хатгал ТТЗ	3	15.2					3	15.2				
Дүн	3	15.2					3	15.2				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Хатгал ЗАА	5	25.1	1	0.9	2	3.0	2	21.2				
Дүн	5	25.1	1	0.9	2	3.0	2	21.2				
НИЙТ дүн	8	40.3	1	0.9	2	3.0	5	36.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хатгал ТТЗ	1	-					1	
Харьяа байгууллагуудын зөрчил								
Хатгал ЗАА	0	0.0						
Дүн	0	0.0						
НИЙТ дүн	1	0.0					1	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ								

